

МОНОС ХҮНС ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 06-р сарын 08-ны өдөр

№ 10/06

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус
гишүүнийг чөлөөлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь заалт, 80 дугаар зүйл, Монос Хүнс ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.17.1 дэх заалт болон 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас гарсан шийдвэр, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хорооноос гаргасан санал зэргийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монос хүнс ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Шийтуу овогтой Алтанбагана нь гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт ирүүлсэн байх тул 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. Гишүүн Ш.Алтанбагана чөлөөлөгдсөнтэй холбоотой холбогдох хууль, дүрэм, журмын дагуу гишүүний цалин хөлс, тооцоог хийж дуусгахыг Санхүү хариуцсан захирал /Ц.Дэлгэрмаа/-д зөвшөөрсүгэй.
3. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг орлох этгээдийг хуулийн дагуу сонгон шалгаруулах зарыг 2023 оны 06 дугаар сарын 12 өдрөөс эхлэн 1 сарын хугацаатайгаар олон нийтийн хэвлэл мэдээллийн сувгаар байршуулах, сонгон шалгаруулалтыг хийн ТУЗ-ийн дараагийн ээлжит хуралд танилцуулах, томилуулахыг ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны дарга /Б.Гантулга/-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллагад мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Н.Цагаанхүү/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Х.АНАНД